

Цуврал хичээл-7

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Дэлхий даяар хөрөнгө оруулалтын компани, хөрөнгө оруулалтын сангууд сая, сая хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хуримтлуулж байна. Тэдгээрийг дараа нь нэг хувьцаанд ногдох сангийн цэвэр хөрөнгийн өртгийн хэмжээний орлогоор (net asset value – NAV) худалдаж болно. АНУ-д хөрөнгө оруулалтын санг “АМЕРИКИЙН БАНКНЫ АЛЬТЕРНАТИВ ТОГТОЛЦОО” гэж нэрлэдэг.

1990 – 1993 онд зөвхөн хамтын сангууд гэхэд л 300 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийжээ.

Анхны хөрөнгө оруулалтын компани Бельгид 1822 оны 8-р сард, дараа нь Швейцарьт 1849 онд, Францад 1852 онд байгуулагдаж байсан. Өнөө үед АНУ хөрөнгө оруулалтын үндсэн 3 төрлийн компани, тухайлбал бэлэн өртөгтэй сертификатын сан, удирдлагын сангууд, хөрөнгө оруулалтын нэгдсэн трастууд байгаа. Хөрөнгө оруулалтын нэгдсэн трастад гол үүргийг эрхлэгч биш харин трастыг үндэслэгч, хадгалагч гүйцэтгэдэг. Хадгалагч нь трастыг үндэслэн байгуулж, түүний анхны дилер, эрхлэгч, эзэтшигч, трастад шилжүүлсэн өмч хөрөнгөнөөс орлого хүртэгч байна. Энэ нь хувь оролцооны сертификат юм. Эзэмшигч түүнийг дуртай үедээ худалдан мөнгөө авч болно. Ийм компанид үнэт цаасны богцын (портфель) хэмжээг тогтоосон байдаг. Сан нэрлэсэн өртөгтэй өөрийн сертификатаа өрийн бичигтэй тэнцүүлж болно.

Хөрөнгө оруулалтын удирдлагын сангууд хөрөнгө оруулалтын тогтоосон богцгүй. Байнга хөдөлгөөнд байдаг. Ийм сангууд нээлттэй ба хаалттай төрлийн байдаг. Нээлттэй сангууд илүү түгээмэл байдаг бөгөөд хамтын сан гэж нэрлэгддэг. Хөрөнгө оруулалтын сан заримдаа “хөрөнгө оруулалтын компани” гэсэн ойлголттой ижил утгатай байна. Хөрөнгө оруулалтын сан бүр хувьцаа гаргаж худалдсанаар олсон орлогоосоо үнэт цаасд оруулдаг. Ингэхдээ “УДИРДАХ КОМПАНИ” гэж нэрлэгдэх толгой компанид сангийн хувьцаа, эсвэл хяналтын багцаа хадгалуулна. Үүнээс гадна хөрөнгө оруулалтын бас нэг сангийн төрөл бол “мөнгөний зах зээлийн хамтын сан” юм. Тэд хамтын сан шиг үйл ажиллагаа явуулахаас гадна хамгийн аюулгүй, түргэн хөрвөдөг, богино хугацааны Засгийн газрын өрийн үүрэг, сангийн вексель, арилжааны бичиг, хадгаламжийн сертификат зэргийг хувьцаа, өрийн бичгийн хажуугаар худалдан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ?

Хөрөнгө оруулалтын сан нь нэг талаас зээл санхүүгийн зах зээлийн институт, нөгөө талаас хувьцаагаа худалдаж янз бүрийн үнэт цаасанд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгө эзэмшигчдийн хамтын хөрөнгө оруулалтыг удирдаж байгаа хуулийн этгээд юм.

Sovereign wealth fund (SWF) буюу Үндэстний хөрөнгө оруулалтын сан нь төрийн оролцоотой байдаг ба санхүүгийн актив, үнэт цаас, бонд, өмч, үнэт метал болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг багтаадаг. Үндэстний хөрөнгө оруулалтын сан нь тухайн үндэстний мөнгө санхүүг тогтоон барьж, санхүүгийн бусад эх үүсвэрүүд рүү хуваарилалт хийх институт болж өгдөг.

Ерөнхийдөө төсвийн давсан орлогыг төвлөрүүлэн хий дэмий хадгалаад байх биш тодорхой хувийг нь одоо болон ирээдүйд үр ашгаа өгөх эх үүсвэрүүд рүү оруулж өгдөг. Улс орон бүхэнд үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан нөхцөл байдлууд нь өөр өөр байдаг.

Үндэстний хөрөнгө оруулалтын сан нь хамтын зах зээлийн эдийн засаг дээр суурилах учраас чөлөөт зах зээлийн эдийн засгаас татгалзаж улс төрийн социал демократ идеологийг баримтлах ёстой.

Үндэстний хөрөнгө оруулалтын сан бүрдэхэд 3 үе шатыг дамжсан

- 1950 – 1970 оны үед анхны хөрөнгө оруулалтын сангууд байгуулагдаж багахан тооны үндэстний хөрөнгө оруулалтын сангууд нь томоохон экспортлогчид болж эхэлсэн.

- 1970 – 1990 оны үед үндэстний хөрөнгө оруулалтын сангийн хандлага нь өөрчлөгдөж эхэлсэн-зарим том сангууд бий болсон.

- 1990 – 2008 үндэстний хөрөнгө оруулалтын сангийн тоо огцом өсч мөн 1990-ээд оноос эдийн засгийн хямрал эхэлсэнтэй холбоотойгоор шинэ хэлбэрүүд гарч эхэлсэн.

Абу Дабигийн (Abu Dhabi's)-гийн хөрөнгө оруулалтын сан 1976 онд байгуулагдсан 875 тэрбум ам долларын активтай,

Сингапурын засгийн газрын хөрөнгө оруулалтын корпораци 1981 онд байгуулагдсан 330 тэрбум ам долларын активтай,

Норвегийн тэтгэвэр тэтгэмжийн сан 1990 онд байгуулагдсан 443 тэрбум ам долларын активтай.

Эдгээр үндэстний хөрөнгө оруулалтын сангууд нь дэлхийд тэргүүлэгч сангууд юм. Үндэстний хөрөнгө оруулалтын сангуудын нийт актив 2010 оны байдлаар 6 триллион ам доллар байгаа ба 2020 онд 20 триллион амдоллар болж өснө гэсэн таамаглал байна.

Үндэстний хөрөнгө оруулалтын сангууд нь зөвхөн нэг улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаггүй олон улсыг хамарсан санхүү, эдийн засгийн

тогтолцоог үүсгэдэг. Хэрвээ Монгол улс дэлхийн зах зээл дээр гарч, хүн төрөлхтөнтэй хөл нийлүүлэн алхая гэвэл үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжтой.

Дэлхийд тэргүүлэгчид болох Арабын нэгдсэн Эмират болон Норвегийн хөрөнгө оруулалтын сангууд нь газрын тосноос олсон орлогоо үрэн таран хийлгүй тодорхой хувийг нь эдийн засгийн бусад салбарууд руу оруулан, тэгж чадсанаараа үндэстний хэмжээний томоохон корпорациудыг бий болгож чадсан

Монгол улсын хувьд өнөөдрийн байдлаар ДНБ нь 5 тэрбум ам долларт хүрч, уул уурхайгаас орж ирэх мөнгө нь жилээс жилд нэмэгдэн мөнгөний томоохон урсгалтай болж чадсан. Энэ бүхний хажуугаар олон сөрөг үзэгдлүүд байгаа Монгол улсад боловсруулах аж үйлдвэр, техник технологи, мэдлэгт суурилсан хөгжил явагдахгүй, хүн төрөлхтний хоцрогдсон аргуудыг ашигласан дэндүү болхи систем үйлчилж байна.

Монгол улс 1921-1990 онд ХАА-н нийгмээсээ тодорхой хэмжээгээр салж аж үйлдвэржсэн орон болж чадсан, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, аж үйлдвэрийн комбинат, мод боловсруулах комбинат, гурилын үйлдвэр зэрэг олон үйлдвэр, комбинатуудыг барьж босгон ази тивдээ үлгэрлэх орон болж чадсан.

Үндэстний хөрөнгө оруулалтын сангийн 3 төрөл байдаг байна.

1. Байгалийн нөөц дээр тулгуурласан сангууд: Жишээ: Орос, Арабын нэгдсэн Эмират улсуудын хөрөнгө оруулалтын сангууд иймэрхүү маягаар ажилладаг.

2. Гадаад валютын нөөцийн дээр тулгуурласан сангууд Жишээ нь: Хятад, Сингапур.

3. Тэтгэвэр, тэтгэмжийн нөөц дээр тулгуурласан сангууд Жишээ: Норвеги, Европын орнууд.

Үндэстний хөрөнгө оруулалтын сангийн орлогын эх сурвалж нь:

1. Ашигт малтмал байгалын баялгийн нөөц
2. Гадаад валютын нөөц
3. Тэтгэвэрийн сан
4. даатгалын сан
5. Үндэстний төрийн өмчит корпорациудын орлого

Сингапурын хөгжлийн гайхамшиг Тимасекийн, Норвегийн хөгжлийн гайхамшиг Норвегийн тэтгэвэр тэтгэмжийн хөрөнгө оруулалтын сангуудтай холбоотой. Япон, Солонгос, Хятад, АНЭ, Саудын Араб зэрэг орнуудыг яаж энэ их гайхамшигт хөгжилд хүрсэнийг гайхаад суух биш эдгээр улсуудын эдийн засаг, санхүүгийн нууцтай танилцах хэрэгтэй.

Үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулж байж мэдлэгийн нийгэм, мэдлэгийн эдийн засаг, инновацийн талаар ярих боломжтой болно.

Эдгээр хүчин зүйлүүдийн санхүү, эдийн засгийн асуудлыг шийдхийн тулд хөрөнгө оруулалтын сан зайлшгүй хэрэгтэй.

Монгол улс үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжтой аргууд ба бодит байдал:

Байгалын баялаг, Гадаад валютын нөөц , Тэтгэвэр тэтгэмжийн сан

Тэтгэвэр тэтгэмжийн санд ард түмэн ирээдүйгээ даатгадаг.

Норвеги орон өнөөдрийн хөгжилд хүрэхдээ тэтгэвэр, тэтгэмжийн сангийн тодорхой хувиараа үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулж түүгээрээ бусад эх үүсвэрүүддээ хөрөнгө оруулалт хийсэн юм. Монгол улс 3 тэрбум ам долларын гадаад валютын нөөцтэй. Тэр нөөцөө гадны банкинд жилийн 1%-ийн хүүтэйгээр хадгалуулдаг. Монгол банкны бодлогын хүү жилийн 12.25%-тай байна. Үүнийг дагаад банкнуудын хүүгийн түвшин 18%-24%-ийн хооронд хэлбэлзэж байна. Байгалийн баялаг, уул уурхайг зөв ашиглаж чадвал Монгол улсын хөгжлийн гараа болж чадна.

Газрын тосоор эхлэн босож үндэстний хөрөнгө оруулалтын санг байгуулан түүгээрээ хөгжилд хүрсэн олон орон байдгийг дээр хэлсэн. Тэгэхлээр Монгол улс уул уурхайгаас олсон орлогоо халамж хэлбэрээр биш мэдлэг боловсрол, үйлдвэрлэлдээ зарцуулвал хөгжил ойрхон л харагдаж байна. Хөгжилд хүрсэн дэлхийн тэргүүлэгч орнууд бүгд үндэстний хөрөнгө оруулалтын сангуудыг байгуулан түүгээрээ эдийн засгаа дэмжсэний үндсэн дээр амжилтанд хүрсэн байдаг.

Монгол улсад үндэстний хэмжээний томоохон корпорацуудыг байгуулан түүнийгээ дэлхийн зах зээлтэй холбоход дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалтын сан, дэлхийн зах зээл дээр Монголын корпорацуудын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын сан байгуулах хэрэгтэй.

Монгол улс Тэтгэвэр тэтгэмжийн сан, Гадаад валютын нөөц, Байгалын баялагийн ашиглалтаа зөв замд нь оруулж чадвал, түүнээс олсон орлогоороо үндэстний хөрөнгө оруулалтын сан байгуулж мэдлэгийн эдийн засаг, мэдлэгийн нийгэмд шилжих эхэллээ тавьж чадна. Энэ бол хөгжлийн хамгийн зөв бас дөт гарц юм.

Үндэстний хөрөнгө оруулалтын сан нь Одоо болон Ирээдүй үеийн нийгмийн асуудлуудыг шийдэж, холыг харсан зөв бодлого явуулан, улс орныг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлж чадна. Үүний тулд дээр хэлсэнчлэн улс төр болоод эдийн засгийн таатай орчин бүрдсэн байх учиртай.

Одоо үе: орон сууц, тулгамдсан асуудал, бүтээн байгуулалт, ажлын байр

Ирээдүй үе: мэдлэг боловсрол, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал, шинжлэх ухаан Зэрэг асуудлуудыг шийдэхэд хөрөнгө оруулалтыг хуваарилах.

ХОС-гийн төрлүүд:


Хаалттай, нээлттэй гэсэн хоёр төрлийн хөрөнгө оруулалтын сан байдаг.

Нээлттэй санд иргэд хүссэн үедээ, хүссэн хэмжээгээрээ хөрөнгө оруулалт хийж болно. Мөн хэрэгцээтэй үедээ санд оруулсан хөрөнгөө буцаан татаж болно.

Харин хаалттай санд орох хөрөнгө оруулагчдын тоо хязгаартай бөгөөд сангаас хүссэн үедээ гарах боломжгүй байна. Хаалттай сан нь ихэвчлэн үйл ажиллагаа явуулах тодорхой хугацаатай байдаг бол нээлттэй сан тодорхой тогтоосон хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

ХОС-гийн давуу ба сул тал:

Хөрөнгө оруулалт хийх, мөнгөн хөрөнгийг зөв зохистой байршуулахад мэргэжлийн мэдлэг туршлага шаардагддаг. Тухайлбал, эдийн засаг, санхүү,



бизнес, маркетинг зэрэг маш олон салбарын өндөр мэдлэгтэй байх ёстой. Тийм ч учраас хөрөнгө оруулалтын сайн менежер болоход ихээхэн цаг хугацаа шаардагдана. Хөрөнгө оруулалтын сангуудыг туршлагатай сайн менежерүүд удирддаг учраас харьцангуй эрсдэл багатай байдаг. Сул тал нь итгэл дааж, хариуцлагатай ажиллах мэргэшсэн сангийн менежер ховор, тогтвортой ажиллах баталгаа бага, өөрийн өмчийн талаар шийдвэр гаргах эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг. Хувьцаа, бонд болон хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулахдаа тэдгээрийн өгөөж болон эрсдлийг хэрхэн үнэлэх, хөрөнгө оруулалтын шалгуурын талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсч байгаа бол